

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ДОТООД АУДИТЫН АЛБА



**ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН
АЖЛЫН ТАЙЛАН**

2024

ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРЛЫН ШИЙДВЭРЭЭР УДИРДАМЖ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ УЛААНБААТАР ХОТ, ОРОН НУТАГ ДАХЬ САЛБАР ТӨВҮҮДИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛАГААНД ТӨЛӨВЛӨГӨӨТ БОЛОН ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ. Төв аймгийн салбарын үйл ажиллагаанд дотоот аудит хяналт шалгалт хийсэн ажлын танилцуулга

Үйлдвэрийн газрын Захиргаа сургалт, хүний нөөцийн хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу 01 дүгээр сарын 12-ний өдөр Төв аймгийн автотээврийн төвийн үйл ажиллагаанд дотоот аудит, хяналт шалгалт хийх, хууль тогтоомж, заавар, журам, захирлын тушаал шийдвэрийн хэрэгжилтэд хяналт, шалгалтыг хийж эрсдэл үүсэх, зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажилласан.

Тус төв нь 1 дүгээр сарын 1-нээс 12 сарын 31-ныг хүртэлх орлогын төлөвлөгөө 390.2 сая төгрөг, биелэлт 491.6 сая төгрөг буюу 125.9%-ийн биелэлттэй, зардлын төлөвлөгөө 448 сая биелэлт 372.4 сая төгрөг буюу 83.1%-ийн биелэлттэй байна .

Төв аймгийн автотээврийн төвийн 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дүгээр сарын 31-нийг дуустал нягтлан бодогчийн санхүүгийн холбогдох тайлан болон нярвын санхүүгийн гаргасан тайлангуудад аудит хийж, анхан шатны баримтын хөтлөлт , маягт үнэт цаас тооллого хийн шалгасан.

Дүгнэлт:

- Шалгалтын явцад бараа материалын 2023 оны 3 дугаар сарын тайлан дэлгэрэнгүй тайлангийн ахлах нягтлан бодогчийн болон няравын тайлан зөрүүтэй .
- Няравын гаргасан тайланг ахлах нягтлан хянан шалгахгүйгээр гарын үсэг зуран баталгаажуулсан.
- Зөрүүтэй тайланг дараа сарын тайлантай тааруулсан.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан

- 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.
- 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.

Зөвлөмж:

1. Нярав тайланг үнэн, зөв гарган ахлан нягтлан бодогчид хянуулан, шалгуулж гарын үсэг зуралцан баримтжуулж хэвших.
2. Ахлах нягтлан бодогч нярвын гаргасан тайланг нягтлан шалгасны үндсэн дээр гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар баталгаажуулж хэвших.
3. Ахлах нягтлан бодогч тайланг санхүүгийн программ болох Unicus программаас сар бүрийн тайланг гаргаж нярвын тайлантай хавсаргаж гарын үсэг зуралцан баримтжуулж хэвших.

ХОЁР. Баянзүрх техникийн хяналтын үзлэгийн төвд дотоод аудитаар хийгдсэн ажлын тайлан

Хяналт-шинжилгээ, дотоод аудитын албаны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.3-д зааснаар Баянзүрх техникийн хяналтын үзлэгийн төвд 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаанд дотоод аудит хийх, хууль тогтоомжийн хэрэгжилт, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, үр дүнгээр нь дотоод аудитын дүгнэлт гаргаж, зөвлөмж хүргүүлэхэд оршино.

1.1 Ажиллах хугацаа:

2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр

Дотоод аудит, хяналт шалгалт хийх ажлын чиглэлээр:

2024 оны 1 дүгээр улирлын инженер, техникийн ажилчдын тайлан /өдөр тутмын/, харилцахын холбогдох баримтууд, бараа материал, үнэт цаасны тайлан зэрэг санхүүгийн анхан шатны баримтуудад санхүүгийн аудит хийж, заавар зөвлөмж өгөх

2.1 Дотоод аудит хяналт шалгалт хийх ажлын хүрээнд:

Санхүүгийн аудитын ажлыг гүйцэтгэхдээ Баянзүрх техникийн хяналтын үзлэгийн төвийн ахлах нягтлан бодогч, нярав, бичиг хэрэг нарын 2024 оны 1 дүгээр улирлын үзлэгийн инженерүүдийн тайлан /өдөр тутмын/, харилцахын холбогдох баримтууд, бараа материал, бичиг хэргийн тайлан зэрэг санхүүгийн анхан шатны баримтуудад санхүүгийн аудит хийж бусад холбогдох баримт материалыг үндэслэн шалгалтын ажлыг явуулсан.

Мөн тус төвийн 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 31-ыг хүртэлх өдрүүдийн нягтлан бодогчийн санхүүгийн холбогдох тайлан болон няравын санхүүгийн гаргасан дараах тайлангуудад аудит хийж, анхан шатны баримтын хөтлөлтийг тус тус шалган ажиллаа.

Тус төвийн 2024 оны жилийн орлогын төлөвлөгөө 2.258 тэрбум төгрөгөөр батлагдсан.

1 дүгээр улирлын байдлаар

- Техникийн хяналтын үзлэгийн орлого 500.08 сая төгрөг төлөвлөгдснөөс 555.45 сая төгрөг **110** хувийн гүйцэтгэлтэй
- Дүгнэлтийн орлого 9.6 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 12 сая төгрөг **130** хувийн гүйцэтгэлтэй

Нэг дүгээр улирлын орлогыг бүтэн жилийн орлогын төлөвлөгөөтэй харьцуулахад 567.45 сая төгрөг буюу 25 хувийн биелэлттэй явж байна.

Хүснэгт 1. 1 дүгээр улирлын орлогын гүйцэтгэл /хувиар/

2024 оны төлөвлөгөө		Гүйцэтгэл	Хувь
Нийт дүн	2,258,630,000	567,458,000	25%

Хүснэгт 2. 2024 оны 1-р улирлын орлогын төлөвлөгөө болон биелэлтийн задаргаа

№	Тээврийн хэрэгслийн марк	Төлөвлөгөө	Биелэлт	Төлөвлөгөө	Биелэлт
1	Суудал	22,350	22,905	447,000	458,100
2	Ачаа	1,557	2,972	46,710	89,160
3	Автобус	100	233	3,000	6,990
4	Чиргүүл	96	10	960	100
5	Шинэ т/х	170	138	337	273
6	Мотоцикл	208	78	2,080	780
7	A/75 осол	120	150	9,600	12,000
8	Ерөнхий үзлэг	0	1	-	50
9	Ерөнхий үзлэг	0	-	-	-
Дүн		24,601	26,487	509,687	567,453

Үүнээс харахад сард дунджаар 24601 тээврийн хэрэгсэл үзлэгт хамрагдан 169.89 сая төгрөгийн орлого олж байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 3. Сар бүрийн гаргасан орлогын мэдээллийн задаргаа

Д/д	Тээврийн хэрэгслийн тоо	Орлого
1 дүгээр сар	8314	173,707,000
2 дугаар сар	6724	139,919,000
3 дугаар сар	9563	196,061,000

Тус төвийн 2024 оны зардлын төлөвлөгөө 331.39 сая төгрөг, гүйцэтгэл 249.5 сая төгрөг буюу 75.3 хувийн биелэлттэй 81.89 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна.

Хүснэгт 4. Зардлын биелэлтийн задаргаа

Үзүүлэлт	Гүйцэтгэл өссөн дүнгээр
Үндсэн болон нэмэгдэл цалин-Үндсэн ажилчид	136,771,726.88
Хоол унааны хөнгөлөлт-Үндсэн ажилчид	28,504,000.00
ЭМД ба НДШ-ийн зардал -Үндсэн ажилчид	21,690,409.68
Ашиглалтын зардал-Цахилгаан	2,657,800.37
Ашиглалтын зардал-Дулаан	3,704,319.33
Ашиглалтын зардал цэвэр, бохир ус	228,973.16
Ашиглалтын зардал Түрээс	5,890,909.08
Ашиглалтын зардал-Суваг ашиглалт	780,000.00
Ном хэвлэл,товхимол тараах материал	800,000.00
Засварын зардал-Сэлбэг/тоног төхөөрөмж/	500,000.00
Бичиг хэргийн зардал	611,766.28
ХөХам Аюулгүй ажиллагааны зардал	2,461,436.89
Элэгдлийн зардал	22,816,315.43
Төлбөр хураамж, жижиг татварууд	10,708.00
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал /Захиргаа/	150,000.00
Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж	11,400,000.00
Ажилчдын арга хэмжээний зардал	250,000.00
Үндсэн ба нэмэгдэл цалин-Удирдлага	7,875,000.00
Хоол унааны хөнгөлөлт-Удирдлага	1,240,000.00
ЭМД ба НДШ-ийн зардал-Удирдлага	1,170,025.00
Банкны үйлчилгээний хураамж	15,700.00
Хүүгийн орлогын шимтгэл	15,795.09
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	249,544,885.19

Санхүүгийн смарт систем Юникус дэх кассын тайланг, нярав, бичиг хэргийн бэлэн мөнгөнд тооллого хийхэд 221.26 мянган төгрөг буюу үлдэгдэл зөрүүгүй.

2.2.2 Дотоод аудит хяналт шалгалтын дагуу өгөх зөвлөмж:

- ❖ НББ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог үндэслэл болгон заалтыг мөрдөн ажиллах
- ❖ Нягтлан бодогч, нярав нарын хоорондын ажлын уялдааг сайжруулах, санхүүгийн анхан шатны баримт, агуулахын бүртгэл хөтлөлтөд анхааран санхүүгийн баримтыг төрөл зүйлээр нь ялган, хяналт тавьж гарын үсэг зурж баримтжуулах
- ❖ НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна гэсэн заалтыг мөрдөн ажиллах

ГУРАВ. Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төвд хийсэн ажлын танилцуулга

Хяналт-шинжилгээ, дотоод аудитын албаны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.3-д зааснаар Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төвд 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс 09-ны өдрийн хооронд 4 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаанд нь дотоод аудит хийх, гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт болон ажилтан тус бүрийн ажлын явц тайлан, ажил үүрэг, хууль тогтоомж заавар, журам захирлын тушаал шийдвэрийн хэрэгжилтийн байдлыг хянах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, үр дүнгээр нь дотоод аудитын дүгнэлт, зөвлөмж гаргах замаар үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх удирдлагыг мэдээллээр хангах тал дээр онцгойлон анхаарч ажиллалаа.

Санхүүгийн аудитын чиглэлээр өгөх зөвлөмж:

1. Нягтлан бодох бүртгэлийн хуулийн "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн 13.1-д заасан заалтыг баримтлан ажиллах.
2. Нягтлан бодох бүртгэлийн хуулийн "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" гэсэн 13.5-д заасан заалтыг баримтлан ажиллах.
3. НББ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "Анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог үндэслэл болно" гэсэн заалтыг мөрдөн ажиллах

4. Нягтлан бодогч, нярав нарын хоорондын ажлын уялдааг сайжруулах, санхүүгийн анхан шатны баримт, агуулахын бүртгэл хөтлөлтөд анхааран санхүүгийн баримтыг төрөл зүйлээр нь ялган, хяналт тавьж гарын үсэг зурж байх.
5. Тус төвийн 2024 оны зардлын төлөвлөгөө гараагүй.

Дөрөв. Хэнтий аймгийн салбарын үйл ажиллагаанд дотоот аудит хяналт шалгалт хийсэн ажлын танилцуулга

Үйлдвэрийн газрын захирлын 2024 оны 09 дүгээр сарын 13-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Хяналт шинжилгээ дотоод аудитын албаны 3 хүний бүрэлдэхүүнтэй 2024 оны 09 дүгээр сарын 16--17-ны өдрүүдэд ажиллав. Ажиллах хугацаанд салбар төвүүдийн өдөр тутмын үйл ажиллагаа, дотоод хяналтаар салбарын 2024 оны эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлт, хууль тогтоомжийн хэрэгжилт биелэлт, орлого зардлын гүйцэтгэл, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаа, баримтын бүрдэл гүйцэтгэл, шилэн дансны гүйцэтгэл, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, зөвшөөрлийн бичгийн зарцуулалт зэрэгт дотоод хяналт шалгалтын ажил хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирлын тушаалаар тус төвийн ажиллах орон тоо болон ажиллагсдын цалингийн сүлжээг хүн бүрээр тогтоож өгсөн ба түүнийг мөрдөж ажиллаж байна. Тус аймгийн автотээврийн төв нь 12 хүний орон тоотой ажиллаж байна



Тус салбар нь төлөвлөгөөгөөр 2024 онд нийт 447,540.00₮-ийн орлого төвлөрүүлэхээс 2024 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 403,642.60₮ буюу 90.2 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. Зардлын хэмжээ 381,372.5₮ гэж төсөвлөснөөс 340,316.20₮ зарцуулалттай 89%-ийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.

Дотоод аудит хяналт шалгалтын дагуу өгөх зөвлөмж:

- Бараа материалын зарлагын анхан шатны баримт, томилолтын тайлангийн бүрдэл илтгэх хуудас зэрэг баримтын бүрдлийг бүрдүүлэх, шаардах хуудасны бичилтэд анхаарах
- Шилэн дансны хууль болон, шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлж ажиллах

ТАВ. Сүхбаатар аймгийн салбарын үйл ажиллагаанд дотоот аудит хяналт шалгалт хийсэн ажлын танилцуулга

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирлын тушаалаар тус төвийн ажиллах орон тоо болон ажиллагсдын цалингийн сүлжээг хүн бүрээр тогтоож өгсөн ба түүнийг мөрдөж ажиллаж байна. Тус аймгийн автотээврийн төв нь 16 хүний орон тоотой ажиллаж байна.



Тус салбар нь төлөвлөгөөгөөр 2024 онд нийт 511,626.00₮ орлого төвлөрүүлэхээс 2024 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 690,765.00₮ буюу 135.01%-ийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. Зардлын хувьд 432,450.60₮ гэж төсөвлөснөөс 424,210.70₮ зарцуулж 98.09%-ийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.

2024 оны бараа материалын тайлан байхгүй, учир нь бүртгэлийн ажилтан нь бичиг хэрэг, нярвын ажил хавсарч хийдэг байсан бөгөөд өөрийн ажлаа хийнэ гээд нярав, бичиг хэргийн ажлыг орхигдуулсан, 8 сарын 1-ээс шинэ нярав бичиг хэргийн ажилтан авсан. 2023 оны баримт үзсэн. Бараа материалын орлого, зарлагын баримт, шаардах хуудасны бичилт буруу, гарын үсэг дутуу байна. /Нярав өөрөө бичээд, өөрөө олгоод, өөрөө хүлээж авсан гэх мэт/

Үнэт цаасны тайланг зөв гаргаж, тавигдах хяналтыг сайжруулах удирдлагаар хянуулж, цохолт хийлгэж хэвших. 09 дүгээр сарын 17-ны өдрөөр үнэт цаасны үлдэгдэлд тулгалт хийсэн ба тооцооны хуудас 200ш зарлагдаагүй бусад үлдэгдэл таарсан. Бараа материал хадгалах сейф эмх цэгцгүй, баримт бичиг замбараагүй, томилолтын тайлан бүрдэл дутуу тайлбар бичүүлж авсан.

Дотоод аудит хяналт шалгалтын дагуу өгөх зөвлөмж:

- Бараа материалын зарлагын анхан шатны баримт, томилолтын тайлангийн бүрдэл илтгэх хуудас зэрэг баримтын бүрдлийг бүрдүүлэх, шаардах хуудасны бичилтэд анхаарах

- Шилэн дансны хууль болон, шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлж ажиллах

ЗУРГАА. Дорнод аймгийн салбарын үйл ажиллагаанд дотоот аудит хяналт шалгалт хийсэн ажлын танилцуулга

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирлын тушаалаар тус төвийн ажиллах орон тоо болон ажиллагсдын цалингийн сүлжээг хүн бүрээр тогтоож өгсөн ба түүнийг мөрдөж ажиллаж байна. Тус аймгийн автотээврийн төв нь 15 хүний орон тоотой ажиллаж байна.

Тус салбар нь төлөвлөгөөгөөр 2024 онд нийт 397,912.00₮-ийн орлого төвлөрүүлэхээс 2024 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 538,584.08₮ буюу 135.40%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Зардлын хувьд 428,173.08₮ гэж төсөвлөснөөс 454,762.10₮ зарцуулж 106.20%-ийн гүйцэтгэлтэй байна



Бараа материалын орлого, зарлагын баримт, шаардах хуудасны бичилт буруу байна. Нярав өөрөө бичээд, өөрөө олгоод, өөрөө хүлээж авсан, баллаж, зассан, штрихдсэн, доош нь дүнгээр нь хаалгүй орхидог, Анхан шатны баримтын огноо засварласан, баримт хаадаггүй нэмж тэмдэглэгээ хийдэг.

09 дүгээр сарын 19-ны өдрөөр үнэт цаас болон бараа материал үлдэгдлийн тулгалт хийсэн, зөрчил илрээгүй. Үнэт цаас, баримт бичгийн хадгалалт эмх цэгц маш сайн байсан.

2024 оны 03 дугаар сард Дорнод аймаг дахь төрийн аудитын газраас аудит орсон бөгөөд зөвлөмжөөр НББ хөтлөлт дээр “Шатахуун зарлагдахдаа шаардах хуудас хөтөлж ажиллаагүй” гэсэн алдаа зөрчилтэй гарсан.

Дотоод аудит хяналт шалгалтын дагуу өгөх зөвлөмж:

- Бараа материалын зарлагын анхан шатны баримт, томилолтын тайлангийн бүрдэл илтгэх хуудас зэрэг баримтын бүрдлийг бүрдүүлэх, шаардах хуудасны бичилтэд анхаарах
- Шилэн дансны хууль болон, шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлж ажиллах

ДОЛОО. Сонгинохайрхан зорчигч тээврийн төвд дотоот аудит хяналт шалгалт хийсэн ажлын танилцуулга

2024 оны 10-р сарын 21-ний өдөр Үйлдвэрийн газрын захирлын баталсан “Сонгинохайрхан зорчигч тээврийн төвийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийж, ажлын байрны зураг авалт хийх ажлын удирдамж”-н дагуу Сонгинохайрхан зорчигч тээврийн төвд 2024 оны 10-р сарын 22-25-ны өдрүүдэд 6 хүний бүрэлдэхүүнтэй хяналт шалгалт хийв.

Ажиллах хугацаанд СХЗТТ-ийн өдөр тутмын үйл ажиллагаа, дотоод хяналтаар салбарын 2024 оны 3-р улирлаар орлого зардлын гүйцэтгэл, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаа, баримтын бүрдэл, шилэн дансны гүйцэтгэл, нягтлан бодогчийн санхүүгийн холбогдох тайлан болон нярвын гаргасан санхүүгийн тайлангуудад аудит хийж, анхан шатны баримт хөтлөлт, тасалбар түгээгч нарын кассын бэлэн мөнгөнд тооллого хийж шалгалт хийв.

Сонгинохайрхан зорчигч тээврийн төвд батлагдсан орон тоогоор нийт **48** ажилтны орон тоо батлагдсанаас 45 үндсэн ажилтан, 3 гэрээт албан хаагчтай үйл ажиллагаа явуулж байна.



Тус төв нь 1 дүгээр сарын 1-нээс 9 сарын 30-ныг хүртэлх орлогын төлөвлөгөө 2 тэрбум 665 сая 600 мянган төгрөг, биелэлт 3 тэрбум 876 сая 645 мянга 885.4 төгрөг буюу 145%-ийн биелэлттэй байна. Зардал: Төв нь 1 дүгээр сарын 1-нээс 9 сарын 30-ныг хүртэлх зардлын төлөвлөгөө 1 тэрбум 551 сая 291 мянга 689 төгрөг, биелэлт 1 тэрбум 536 сая 859 мянга 844 төгрөг буюу 99%-ийн биелэлттэй байна. Сонгинохайрхан зорчигч тээврийн төвийн зардлын төлөвлөгөө шилжилт хөдөлгөөн хийгдэхээс өмнө төлөвлөгдсөн тул суваг

ашигласны, урсгал засварын, дулааны зардал, цэвэр бохир усны зардлууд өндөр зардалтай гарсан байна.

Шалгалтаар: Тасалбар түгээгч нарын ширээ, сандал, сейф, бэлэн мөнгө хадгалах шүүгээ эвдэрхий, ажлын байраа түр орхихдоо бэлэн мөнгөө ил орхиж явах, компьютерын дэлгэцээ нээлттэй орхиж байгаа зэрэг алдаа дутагдал илэрсэн. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг шалгаж үзэхэд ажилтнууд дээрх эд хөрөнгийн бүртгэл харилцан адилгүй байна.

ЗТХЯ болон Үндэсний аудитын газрын 2023 оны аудитын тайланд өгсөн зөвлөмжийн дагуу:

- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу тооцож хөрөнгийн үлдэгдлийг буруу тайлагнасан.- Холбогдох хууль, дүрэм, журам, тогтоосон стандартын дагуу “АТҮТ” ТӨҮГ-н НББ-ийн бодлогын баримт бичгийн 390.9 Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцох “Компьютер, түүний дагалдах хэрэслийн ашиглалтын хугацаа 3жил” заалтыг баримтлан элэгдлийн зардлыг залруулан тооцож,
- Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг харилцан адилгүй буюу зөрүүтэй тооцсон хөрөнгийн дансны ангиллыг буруу бүртгэсэн.- “АТҮТ” ТӨҮГ-н НББ-ийн бодлогын баримт бичгийн 390.9 Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцох “Компьютер, түүний дагалдах хэрэслийн ашиглалтын хугацаа 3жил” заалтыг баримтлан үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг 3 жил болгон залруулан бүртгэж,
- Түрээсийн гэрээний нэмэлт өөрчлөлтийг гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулаагүй буюу үндсэн гэрээний холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй.- “АТҮТ” ТӨҮГ-ын 2023 оны ТГ23/08 тоот гэрээний нэмэлт өөрчлөлтийг гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулан үндсэн гэрээний холбогдох заалтуудыг хэрэгжүүлж алдаа зөрчлүүдийг арилгасан байна.

Дотоод аудит хяналт шалгалтын дагуу өгөх зөвлөмж:

Хөдөлмөрийн дотоод журмын 2.13, 2.17, 2.18, 5.1.2, 5.1.11, 5.1.12, 5.1.12, 5.1.13, 5.1.15, 5.1.16, 5.1.20, 5.1.29, 5.1.33, 8.9, 8.11, дэх заалтыг хэрэгжүүлэн ажилладаггүй нийтлэг дутагдал илэрсэний дагуу чанарын менежер, бусад ажилтнуудад дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- Касс орлого авдаг ширээ сандал тоног төхөөрөмжийн иж бүрдлийг хангаж ажиллах

- НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.” заалтыг мөрдөн ажиллах

- НББ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог үндэслэл болно.” заалтыг мөрдөн ажиллах

- Нягтлан бодогч, нярав нарын хоорондын ажлын уялдааг сайжруулах, санхүүгийн анхан шатны баримт, агуулахын бүртгэл хөтлөлтөд анхаарах, үнэт цаасыг дугаарын дагуу тухай бүр нь хяналт тавьж гарын үсэг зурж байх.

- НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг

дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.” заалтыг мөрдөн ажиллах

- Тасалбар түгээгч нарын кассын бэлэн мөнгөнд гэнэтийн тооллого хийж хяналтыг сайжруулах.

- Эд хөрөнгийн бүртгэлийг шинэчлэн бүртгэж, эзэнжүүлэх.

Дотоод аудитын чиглэлээр 2024 онд шалгалтаар нийт 24 зөвлөмж тайланд тусгагдсан . Үүнд:

Төв аймгийн автотээврийн төвд 3 зөвлөмж, Баянзүрх техникийн хяналтын үзлэгийн төвд 3 зөвлөмж, Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төвд 5 зөвлөмж, Хэнтий аймгийн автотээврийн төвд 2 зөвлөмж, Сүхбаатар аймгийн автотээврийн төвд 2 зөвлөмж, Дорнод аймгийн автотээврийн төвд 2 зөвлөмж, Сонгинохайрхан зорчигч тээврийн төвд 7 зөвлөмж тус тус хүргүүлж биелэлтийг заасан хугацаанд ирүүлсэн ба дотоод, хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийг арилган ажилласан байна